



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫН ГИШҮҮН, ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙД Ж.ЧИНБҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatkhural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2025.08.26 № 37

Эрүүл монгол хүний эрхийн  
баталгааг хангах талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тус улсын иргэний баталгаатай эдэлбэл зохих “амьд явах эрхтэй...”, 2 дахь хэсэгт “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, 6 дахь хэсэгт “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрхтэй...” гэсэн эрхийн хэрэгжилт хангалттай бус байна хэмээн үзэж байна. Энэ хүрээнд Засгийн газраас авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ, хэрэгжилтийн үр дүн, тулгамдсан асуудлууд, тэдгээрийн бодит шалтгаан, дээр дурдсан иргэний эрхийн хэрэгжилтийг хангах зорилгоор богино болон дунд хугацаанд төлөвлөж буй зорилт, арга хэмжээний талаарх мэдээлэл;

2. Монгол хүний эрүүл мэндийг хамгаалах асуудалтай шууд болон дам байдлаар холбогдох 60 гаруй хууль тогтоомж байдаг боловч эдгээр хуулийн үйлчлэл мөн хангалтгүй байна. Хэрэв эдгээр хууль бодитойгоор үйлчилдэг байсан бол эрүүл мэндийн салбарт эерэг үр дүн гарах байсан. Монгол хүний эрүүл аж төрөх Үндсэн хуулиар олгосон эрхийг хангах эрх зүйн баталгаа байна уу? Эрүүл мэндийн салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд ойрын хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээлэл;

3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэн бүрд хүртээмжтэй, чанартай хүргэж, тэдний эрүүл аж төрөх, амьдралын чанарыг нь сайжруулахад эрүүл мэндийн салбарын өнөөгийн төсөв, хөрөнгө оруулалт нь санхүүжилтийн хувьд баталгаа болж чадаж байна уу? Үүнтэй холбоотойгоор сүүлийн 10 жилд улсын нэгдсэн төсвөөс эрүүл мэндийн салбарын хөгжилд зориулан зарцуулж ирсэн зарцуулалтын хэмжээ, дотоодын нийт бүтээгдэхүүнд болон улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогод эзлэх хувь, бүтэц, зориулалт, үр нөлөө болон үр дүнгийн талаар шинжилгээ хийсэн эсэх мэдээлэл. Цаашид монгол хүний эрүүл мэндийг хамгаалах төсөв, санхүүгийн баталгааг хангахын тулд Эрүүл мэндийн яамнаас ямар бодлого баримталж байгаа талаарх мэдээлэл;

2025000058

4.Орчны бохирдол, доройтлоос улбаатай хүн амын өвчлөл, эрсдэлийг бууруулах чиглэлээр баримталж ирсэн бодлого, салбар дундын зохицуулалт, уялдаа холбоо, хэрэгжилтийн үр дүнг сайжруулах чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл өгнө үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

С.ЭРДЭНЭБОЛД



2025000058